

БАТЛАВ

БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН  
ТӨВ" УТҮГ-ЫН ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Л.ЭНХБАТ



АХЛАХ АНГИЙН СОНГОН СУДЛАХ ХИЧЭЭЛИЙГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН  
БАРИМТ БИЧИГ

Тендер  
шалгаруулалтын  
нэр:

*Ахлах ангийн сонгон судлах хичээлийг цахим хэлбэрээр зохион  
байгуулах үйлчилгээ*

Тендер  
шалгаруулалтын  
дугаар:

*БМТТ/20240103003*

## I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

### А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1. Тендерийн цар хүрээ**
- 1.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "Хууль" гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон үйлчилгээ (цаашид "үйлчилгээ" гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 1.2.Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 1.3.Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгтэд заана.
- 2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг**
- 2.1.Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.
- 3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж**
- 3.1.Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 4. Худалдан авах ажиллагааны цахим систем**
- 4.1.Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) /цаашид "цахим систем" гэх/-ээр зохион байгуулна.
- 5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх**
- 5.1.Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.
- 5.2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20<sup>1</sup>, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.
- 6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага**
- 6.1.Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.
- 6.2.Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
- 6.3.Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан

байна.

6.4.Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5.Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

#### **7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага**

7.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

#### **Б.АГУУЛГА**

#### **8. Тендер шалгаруулалтын баримт бичиг**

8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2.Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

#### **9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**

9.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

9.2.Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

9.3.Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

9.4.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

9.5.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.

**10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**

10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

**11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах**

11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

**В. ТЕНДЕР БЭЛТГЭХ**

**12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйлчилгээ авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

### **13. Тендерийн иж бүрдэл**

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн үйлчилгээ үзүүлэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6. санал болгож буй үйлчилгээ ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7. ТШЗ-ны 21-д заасан үйлчилгээ үзүүлэх төсөв;

13.2.8. ТШЗ-ны 21.5-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

### **14. Тендерийн жишиг маягтууд**

14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

### **15. Хувилбарт санал**

15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

### **16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг**

16.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:

16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл

оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

#### **17. Чадавхын болон туршлагын шаардлага**

17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

#### **18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**

18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.

18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх

талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

**19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**

19.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

19.2. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

19.3. Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана.

19.4. ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

**20. Санал болгож буй үйлчилгээ шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг**

20.1. Санал болгож буй үйлчилгээ нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

20.2. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

20.3. Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

**21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**

21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.3. Үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг "тендерийн үнэ" гэж үзнэ.

21.4. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.5. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт

ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: <b>“Зөвшөөрөхгүй”</b>
ТШЗ 16.1.21	Тендер шалгаруулалтын баримт бичигт заасан мэдээллийг V бүлгийн холбогдох маягтын дагуу боловсруулж баталгаажуулан ирүүлнэ.
ТШЗ 16.1.2	<p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: <b>“Шаардана”</b></p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Жич: Дээрх лавлагаа авах зааварчилгаатай (www.tender.gov.mn) цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсээс танилцана уу.</p>
ТШЗ 18.1	Санхүүгийн чадавхын шаардлага: <b>“Шаардахгүй”</b>
ТШЗ 18.2	Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг: <b>“Шаардахгүй”</b>
ТШЗ 19.1	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: <b>“Шаардана”</b></p> <p>Оролцогч нь тендер ирүүлэхээр сонгосон багцад заасан ажилласан мэргэжлийн чиглэл, туршлага болон тавигдах шаардлагыг хангасан байна.</p> <p>Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: <b>“Шаардана”</b></p> <p>Сүүлийн 3 хүртэл жил буюу 2021, 2022, 2023 онуудад ижил төстэй үйлчилгээ гүйцэтгэсэн гэрээний талаарх мэдээллийг V бүлгийн Маягт 2-ын дагуу бэлтгэн ирүүлнэ.</p> <p><b>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: “Шаардахгүй”</b></p> <p>Үйлчилгээ үзүүлэгчээс шаардагдах туршлагын доод түвшин: <b>Шаардана</b></p> <p><b>Маягт 10-ын дагуу CV ирүүлнэ. Иргэний үнэмлэхийн хуулбарыг тод гаргацтай авч CV-д хавсарган ирүүлнэ.</b></p> <p><i>Ажиллах хүчний тодорхойлолт:</i> Ахлах ангийн танхимын сонгон судлах хөтөлбөрийг цахим сургалтын хөтөлбөрт шилжүүлж, хэрэгжүүлэх цахим сургалтын багшид зориулсан сургалтын дэлгэрэнгүй төлөвлөлт боловсруулж багшид зөвлөх тусалж сургалтын явц, үр дүнг тайлагнах</p> <p><i>Ур чадвар:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>○ Мэргэжлийн онол арга зүйн болон багшлахуйн чиглэлээр 3-аас доошгүй сургалтад хамрагдсан;</li> <li>○ Цахим орчинд ажиллах ур чадвартай компьютерын хэрэглээний программуудыг эзэмшсэн;</li> <li>○ Бичиж боловсруулах, дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, ур чадвар эзэмшсэн;</li> </ul> <p><i>Боловсрол:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>○ Багш мэргэжлээр их дээд сургууль төгссөн, бакалавр түүнээс дээш боловсролын зэрэгтэй</li> </ul>



	<p><i>Ажилласан туршлага:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>○ Тухайн мэргэжлээрээ ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, боловсролын мэргэжлийн байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан;</li> <li>○ Багш нарт үйлчилгээ үзүүлэгч үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажилласан;</li> <li>○ Онлайн, зайн сургалтын нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан, цахим сургалтын удирдлагын системийн орчинд агуулга хөгжүүлж, сургалт зохион байгуулсан;</li> </ul> <p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: <b>“Шаардана”</b></p> <ul style="list-style-type: none"> <li>○ Сүүлийн 3 хүртэл жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн гэрээ, гэрээ дүгнэсэн актын хуулбар, гэрээний үүргийг чанартай гүйцэтгэсэн талаарх захиалагчийн тодорхойлолт ирүүлэх.</li> </ul>
ТШЗ 19.2	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Сургууль төгссөн дипломын хуулбарыг өөрийн тендерийн саналд ирүүлэх бөгөөд, “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан БШУЯ-ны мэдээллийн сангаас шалгана. “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/-д дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай. Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн бол тендерийн нээлтээс өмнө Боловсролын ерөнхий газрын Цахим шилжилт, нэгдсэн статистикийн газарт хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ үү. Дээрх бүртгэл хийгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу.</li> <li>• Хэрэв гадаадын улс оронд боловсрол эзэмшсэн бол тэдгээрийн дипломын эхээс хийсэн хуулбар, орчуулгын хамт ирүүлнэ.</li> <li>• “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/ системээс мэдээлэл шалгах заавартай дараах холбоосоор танилцана уу. <a href="https://bit.ly/3J1QmHZ">https://bit.ly/3J1QmHZ</a></li> <li>• Ажлын даалгаварт заасан үйлчилгээг хийж гүйцэтгэх төлөвлөгөөг нарийвчлан гаргаж, үйлчилгээ үзүүлэх ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга Маягт 5-ын дагуу ирүүлэх.</li> </ul> <p>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал ТШЗ-д заасан дарааллаар дугаарлан, товъёг хийж тод гаргацтай байх шаардлагатай. Уншигдахгүй материалыг ирүүлээгүйд тооцно.</p>
ТШЗ 19.3	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: <b>“Шаардахгүй”</b>
ТШЗ 21.4	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <b>“Тохируулахгүй тогтмол байна”</b>
ТШЗ 24.1	Тендерийн баталгааны дүн: <b>“Шаардахгүй”</b>

### Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

ТШЗ 25.5	Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: <ul style="list-style-type: none"><li>• ТШЗ 16.1.2-д заасан шаардлага хангасныг нотлох баримт бичиг</li><li>• Тендер шалгаруулалтын баримт бичигт тусгасан маягтын дагуу илгээсэн мэдээлэл;</li><li>• Оролцогч хуульд заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээнэ.</li></ul>
ТШЗ 26.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 5 дугаар сарын 17-ний өдөр Цаг: 10:00 цаг
ТШЗ 26.2	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. 2024 оны 5 дугаар сарын 17-ний өдрийн 10:30 цаг Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: <b>Сүхбаатар дүүрэг 1-р хороо, 13-р хороолол нарны замын 87-р байр 6 давхарт</b>
<b>Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ</b>	
ТШЗ 31.1	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: <b>“Үгүй”</b>
<b>Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ</b>	
ТШЗ 36.1	Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: <b>“Үгүй”</b>

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

#### **Багц № 1: ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЕНЕЖЕРИЙН АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА /ОРОН ТОО -1/**

Гүйцэтгэх үндсэн үүрэг:

- Цахим сургалтын багийн өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу эрхлэн явуулах, удирдлагаар хангах,
- Захиалагчаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллах, шаардлагатай тайлан, мэдээллийг цаг хугацаанд чанартай боловсруулж, хүлээлгэн өгөх,
- Гэрээнд хавсаргасан ажлын даалгаварт заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

Тавигдах шаардлага:

- Боловсролын удирдлага, Багш, Бизнесийн удирдлага, Санхүү, Эдийн засгийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, гадаадын нэр хүндтэй сургууль төгссөн бол давуу тал болно;
- Цахим сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, цахим контент бүтээх, чиглэлээр ажиллаж байсан туршлагатай байх,
- Үндэсний сургалтын хөтөлбөр, сурах бичгийн багт ажилласан туршлагатай байх,
- Цахим сургалт удирдлагын системийн орчинд сургалтын контент хөгжүүлэх, 100 ба түүнээс олон суралцагчид цахим сургалт зохион байгуулж байсан туршлагатай байх,
- Сүүлийн 3 жилд ижил төстэй үйлчилгээг үр дүнтэй гүйцэтгэж ажилласан байх,

#### **ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЕНЕЖЕР ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР БА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАР ХҮРЭЭ**

Үйлчилгээний нэр: "Хөтөлбөр хариуцсан ахлах менежер"

Нэг. Ерөнхий зүйл: БШУ-ы сайдын А/514 дүгээр тушаалаар баталсан "Ахлах ангийн сонгон судлах хичээлийг цахимаар зохион байгуулах түр журам"-ыг хэрэгжүүлэх

Хоёр. Зорилго: Сонгон судлах хөтөлбөрийг цахимаар хэрэгжүүлэх, сургалтын чанарыг үнэлэх, багшийн мэргэжил дээшлүүлэх хэрэгцээнд үндэслэн мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах, сургалтын явц, үр дүнг тайлагнах

Гурав. Хүрэх үр дүн: Ерөнхий боловсролын боловсролын сургууль дээр БШУ-ы сайдын А/514 дүгээр тушаалаар баталсан "Ахлах ангийн сонгон судлах хичээлийг цахимаар зохион байгуулах түр журам"-ыг үндэслэн цахим хэлбэрээр судлах шаардлагатай суралцагчдад орон зайн байршил үл хамааран цахимаар суралцах боломж бүрдүүлэх.

Дөрөв. Гүйцэтгэх ажлын жагсаалт, дэлгэрэнгүй тайлбар:

#### **4.1. Цахим сургалт зохион байгуулах бэлтгэл хангах**

4.1.1. Ахлах ангийн сурагчдын хичээл сонголтыг "Боловсролын мэдээллийн технологийн төв" УТҮГ (цаашид "БМТТ" гэх)-тэй хамтран зохион байгуулах, хичээл сонголтын талаар сургууль болон боловсролын байгууллагуудад мэдээлэл хүргэж хамтран ажиллах,

4.1.2. Сонгон судлах хичээлийг цахимаар судлах сурагчийн хичээлийн хуваарийг ЕБС, БШУГ, НБГ-т хүргүүлэх,

4.1.3. Судалгаанд үндэслэн цахим сургалтын төсвийг тооцоолж, захиалагчид танилцуулах,

4.1.4. Сургалт зохион байгуулах багшид дэмжлэг үзүүлэх "Ахлах багш"-ыг ажиллуулж зөвлөмж өгөх, хичээлийн явцад хяналт хийлгэх боломжийг бүрдүүлэх,

4.1.5. Цахим сургалтад хамрагдаж чадахгүй байгаа сурагчдад дэмжлэг үзүүлэхийн тулд ЕБС-ийн сургалтын менежер, АУБ, сурагч, эцэг эхчүүдэд зөвлөгөө сургалтыг зохион байгуулах;

#### **4.2. Цахим сургалт зохион байгуулах**

4.2.1. Цахим сургалт зохион байгуулах систем, сургалтын хөтөлбөр, багш суралцагчийн гарын авлага, сургалтад хэрэглэх программ хэрэгсэл зэргийг судлан, сургалтын орчин бүрдүүлэхэд чиглэж ажиллах,

4.2.2. Цахим сургалт зохион байгуулахдаа сургалтын ирц, цахим сургалтын багшийн ажлыг үнэлэх, бүртгэл хийх ажлыг зохион байгуулах,

4.2.3. Цахим сургалтын багшийн хөгжлийг дэмжих сургалтын хөтөлбөр, модулийг баг бүрдүүлэн боловсруулж, сургалт зохион байгуулах

- 4.2.4. Цахим сургалтын багш, сурагчдад "өөрийн үнэлгээ" ажлыг зохион байгуулах
- 4.2.5. Цахим сургалтын үйл ажиллагааг дэмжих үйл ажиллагаанууд зохион байгуулах
- 4.2.6. Цахим сургалтын багш бэлтгэх сургалтын модуль боловсруулах, сургалтын төлөвлөгөө гаргах, зохион байгуулах

#### **4.3. Цахим сургалтын явцыг мэдээлэх, тайлагнах**

- 4.3.2. Цахим сургалтын ангиудын ирцийн мэдээллийг ЕБС-д хүргэх ажлыг зохион байгуулах,
- 4.3.4. Цахим сургалтын явцыг хичээлд зохицуулагч нартай хамтран хяналт хийж БШУЯ, БЕГ, БШУГ, НБГ-уудад ирцийн мэдээллийг 7 хоног тутам хүргүүлэх, гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээллийг нэгтгэн архивын нэгж үүсгэж хүлээлгэн өгөх, цахим сургалтын багийн ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээллийг архивын нэгж үүсгэж хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах.

### **Багц № 2: СУРГАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЕНЕЖЕРИЙН АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА /ОРОН ТОО -1/**

Гүйцэтгэх үндсэн үүрэг:

- Ахлах ангийн сонгон судлах хичээлийн хөтөлбөр хариуцсан ахлах багш нарын багийг чадавхжуулах сургалт, үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах,
- Цахимаар хичээл заах багш бэлтгэх модуль сургалт, үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах, зохион байгуулах,
- Ахлах багш нарын багийг удирдлага зохион байгуулалтаар хангах,
- Цахим сургалтын хөтөлбөр, арга зүй, сургалтын чанарт

Тавигдах шаардлага:

- Багш, Боловсрол судлал, Боловсролын удирдлага, төрийн захиргаа, Бизнесийн удирдлага, Мэдээллийн технологийн аль нэг чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй,
- Сургалтын цахим хэрэглэгдэхүүний сан бүрдүүлэх, онлайн зайн сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байсан туршлагатай байх,
- Үндэсний сургалтын хөтөлбөр, сурах бичгийн багт ажилласан туршлагатай байх,
- Цахим сургалт удирдлагын системийн орчинд сургалтын контент хөгжүүлэх, 100 ба түүнээс олон суралцагчид цахим сургалт зохион байгуулж байсан туршлагатай байх,
- Сүүлийн 3 жилд ижил төстэй үйлчилгээг үр дүнтэй гүйцэтгэж ажилласан байх.

### **СУРГАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЕНЕЖЕР ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР БА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАР ХҮРЭЭ**

Үйлчилгээний нэр: "Сургалт хариуцсан ахлах менежер"

Нэг. Ерөнхий зүйл: БШУ-ы сайдын А/514 дүгээр тушаалаар баталсан "Ахлах ангийн сонгон судлах хичээлийг цахимаар зохион байгуулах түр журам"-ыг хэрэгжүүлэх.

Хоёр. Зорилго: Сонгон судлах хөтөлбөрийг цахимаар хэрэгжүүлэх, сургалтын чанарыг үнэлэх, багшийн мэргэжил дээшлүүлэх хэрэгцээнд үндэслэн мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах, сургалтын явц, үр дүнг тайлагнах

Гурав. Хүрэх үр дүн: Ерөнхий боловсролын боловсролын сургууль дээр БШУ-ы сайдын А/514 дүгээр тушаалаар баталсан "Ахлах ангийн сонгон судлах хичээлийг цахимаар зохион байгуулах түр журам"-ыг үндэслэн цахим хэлбэрээр судлах шаардлагатай суралцагчдад орон зайн байршил үл хамааран цахимаар суралцах боломж бүрдүүлэх.

Дөрөв. Гүйцэтгэх ажлын жагсаалт, дэлгэрэнгүй тайлбар:

#### **4.1. Цахим сургалт зохион байгуулах бэлтгэл хангах**

4.1.1. Ахлах ангийн сурагчдын хичээл сонголтыг "Боловсролын мэдээллийн технологийн төв" УТҮГ (цаашид "БМТТ" гэх)-тэй хамтран зохион байгуулах, хичээл сонголтын талаар сургууль болон боловсролын байгууллагуудад мэдээлэл хүргэх;

4.1.2. Сонгон судлах хичээлийг цахимаар судлах сурагчийн хичээлийн хуваарийг ЕБС, БШУГ, НБГ-т хүргүүлэх;

4.1.3. Судалгаанд үндэслэн цахим сургалтын төсвийг тооцоолж, захиалагчид танилцуулах;

4.1.4. Сургалт зохион байгуулах багшид дэмжлэг үзүүлэх "Ахлах багш"-ыг ажиллуулж зөвлөмж өгөх, хичээлийн явцад хяналт хийлгэх боломжийг бүрдүүлэх

4.1.5. Цахим сургалтад хамрагдаж чадахгүй байгаа сурагчдад дэмжлэг үзүүлэхийн тулд ЕБС-ийн сургалтын менежер, АУБ, сурагч, эцэг эхчүүдэд зөвлөгөө сургалтыг зохион байгуулах

#### **4.2. Цахим сургалт зохион байгуулах**

4.2.1. Цахим сургалт зохион байгуулах систем, сургалтын хөтөлбөр, багш суралцагчийн гарын авлага, сургалтад хэрэглэх программ хэрэгсэл зэргийг судлан, сургалтын орчин бүрдүүлэхэд чиглэж ажиллах

4.2.2. Цахим сургалт зохион байгуулахдаа сургалтын ирц, цахим сургалтын багшийн ажлыг үнэлэх, бүртгэл хийх ажлыг зохион байгуулах

4.2.3. Цахим сургалтын багшийн хөгжлийг дэмжих сургалтын хөтөлбөр, модулийг баг бүрдүүлэн боловсруулж, сургалт зохион байгуулах

4.2.4. Цахим сургалтын багш, сурагчдад "өөрийн үнэлгээ" ажлыг зохион байгуулах

4.2.5. Цахим сургалтын үйл ажиллагааг дэмжих үйл ажиллагаанууд зохион байгуулах

4.2.6 Цахим сургалтын багш бэлтгэх сургалтын модуль боловсруулах, сургалтын төлөвлөгөө гаргах, зохион байгуулах

#### **4.3. Цахим сургалтын явцыг мэдээлэх, тайлагнах**

4.3.2. Цахим сургалтын ангиудын ирцийн мэдээллийг ЕБС-д хүргэх ажлыг зохион байгуулах

4.3.4. Цахим сургалтын явцыг хичээлд зохицуулагч нартай хамтран хяналт хийж БШУЯ, БЕГ, БШУГ, НБГ-уудад ирцийн мэдээллийг 7 хоног тутам хүргүүлэх, гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээллийг нэгтгэн архивын нэгж үүсгэж хүлээлгэн өгөх, цахим сургалтын багийн ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээллийг архивын нэгж үүсгэж хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах.

### **Багц № 3-4: СУРГАЛТ ХАРИУЦСАН МЕНЕЖЕРИЙН АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА /ОРОН ТОО -2/**

Гүйцэтгэх үндсэн үүрэг:

- Цахим сургалтын өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах,
- Ахлах багш нарын багт дэмжлэг үзүүлж хамтран ажиллах,
- Цахим сургалтын дизайны загвар хөгжүүлэх,
- Гэрээнд хавсаргасан ажлын даалгаварт заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

Тавигдах шаардлага:

- Багш, боловсролын чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй,
- Статистик боловсруулалтын программууд дээр ажиллах чадвартай,
- хэрэглээний программууд болон интернэтийн орчинд ажиллах чадвартай,
- Цахим сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, цахим контент бүтээх, чиглэлээр ажиллаж байсан туршлагатай байх,
- Хувийн зохион байгуулалт сайтай, харилцааны ёс зүйн төлөвшил өндөр, бүтээлч багаар ажиллах чадвартай байх,

### **СУРГАЛТ ХАРИУЦСАН МЕНЕЖЕР ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР БА ЦАР ХҮРЭЭ**

1. АХЛАХ АНГИЙН СОНГОН
2. Монгол хэл, соёлын нэгдмэл хөтөлбөр

Үйлчилгээний нэр: "Сургалтын дизайн хариуцсан менежер"

Нэг. Ерөнхий зүйл:

Хоёр. Зорилго: Сонгон судлах хөтөлбөрийг цахимаар хэрэгжүүлэхэд сургалтын дизайн гаргах, багш сурагчийн өөрийн үнэлгээний үр дүнд үндэслэн зөвлөмж бэлтгэх, багшийн

цахим ур чадвар, цахим сургалт зохион байгуулах арга зүйн шинэлэг шийдлийг түгээн дэлгэрүүлэх, сургалтын явц, үр дүнг тайлагнах

Гурав. Хүрэх үр дүн: Ерөнхий боловсролын боловсролын сургууль дээр БШУ-ы сайдын А/514 дүгээр тушаалаар баталсан "Ахлах ангийн сонгон судлах хичээлийг цахимаар зохион байгуулах түр журам"-ыг үндэслэн цахим хэлбэрээр судлах шаардлагатай суралцагчдад орон зайн байршил үл хамааран цахимаар суралцах боломж бүрдүүлэх.

Дөрөв. Гүйцэтгэх ажлын жагсаалт, дэлгэрэнгүй тайлбар:

#### **4.1. Цахим сургалт зохион байгуулах бэлтгэл хангах**

4.1.1. Сургалтын үйл ажиллагаанд орчин үеийн шинэлэг технологи, программ хэрэгслүүдийг ашиглан сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр судалгаа хийж, ахлах багш нар, цахимаар хичээл зааж буй багш нартай хамтран аргазүйн шинэлэг санааг боловсруулан турших сайжруулах

4.1.2. Цахим сургалтын дизайн боловсруулах, туршин хэрэгжүүлэх, үр дүнг гаргаж захиалагчид танилцуулах

4.1.3. "Ахлах багш" нартай хамтран сонгон судлах хөтөлбөрийн онцлогийг гаргаж суралцахуйн загвар гаргах

#### **4.2. Цахим сургалт зохион байгуулах**

4.2.1. Цахим сургалт зохион байгуулах сургалтын загвар гаргаж цахим хэрэглэгдэхүүний тооцоо гаргах, турших

4.2.2. Цахим сургалтын өөрийн үнэлгээний үр дүнг 7 хоног бүр "Ахлах багш" нарт танилцуулж судлагдахуун бүрд зөвлөмж өгөх

4.2.3. Судалгааны үр дүнд үндэслэн цахим сургалтын багшийн хөгжлийг дэмжих сургалтын агуулга боловсруулах

4.2.4. Сурагчдын өөрийн үнэлгээний үр дүнд сурагчдад зөвлөгөөг улиралд нэг удаа өгөх

4.2.5. Судалгааны үр дүнд үндэслэн цахим сургалтын явцыг сайжруулах зураглал гаргах

4.2.6. Цахим сургалтын багш, багшийн цахим ур чадварыг сайжруулах сургалтын агуулга боловсруулж хичээл орох

#### **4.3. Цахим сургалтын явцыг мэдээлэх, тайлагнах**

4.3.1. Цахим сургалтын сурагчийн өөрийн үнэлгээний үр дүнд үндэслэн зөвлөмж боловсруулж тайлагнах

4.3.2 Цахим сургалтуудын (багш, сурагч) үр дүнг нэгтгэж тайлагнах, гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээллийг нэгтгэн архивын нэгж үүсгэж хүлээлгэн өгөх.

### **Багц № 5-7: ХИЧЭЭЛ ЗОХИЦУУЛАГЧ МЕНЕЖЕРИЙН АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА /ОРОН ТОО -3/**

Тавигдах шаардлага:

- Багш, захиргаа удирдлага, статистикийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй,
- Статистик боловсруулалтын программууд дээр ажиллах чадвартай,
- Компьютерын өргөн хэрэглээний программууд болон интернэтийн орчинд ажиллах чадвартай,
- Хувийн зохион байгуулалт сайтай, харилцааны ёс зүйн төлөвшил өндөр, бүтээлч багаар ажиллах чадвартай байх.

### **ХИЧЭЭЛ ЗОХИЦУУЛАГЧ МЕНЕЖЕРИЙН ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР БА ЦАР ХҮРЭЭ**

Үйлчилгээний нэр: "Хичээл зохицуулагч менежер"

Нэг. Ерөнхий зүйл: Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/143 дугаар тушаалаар батлагдсан "Цахим сургалт зохион байгуулах" удирдамж, 2022 оны А/514 дүгээр тушаалаар батлагдсан "Ахлах ангийн сонгон судлах хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулах түр журам"-ыг хэрэгжүүлэх.

Хоёр. Зорилго: Сонгон судлах хөтөлбөрийг цахимаар зохион байгуулахад удирдлага, арга зүйгээр хангах, дэмжлэг үзүүлэх, сургалтын явц, үр дүнг тайлагнах.

Гурав. Хүрэх үр дүн: Ерөнхий боловсролын сургууль дээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/491 дүгээр тушаалын

гуравдугаар хавсралтын "Ахлах ангийн сургалтын төлөвлөгөө"-ний сонгон судлах хичээлийг хэрэгцээ сонирхолдоо үндэслэн цахим хэлбэрээр судлах шаардлагатай суралцагчдад орон зайн байршил үл хамааран цахимаар суралцах боломж бүрдүүлэх.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/514 дүгээр журмын хэрэгжилтийг хангаж ажиллах

Дөрөв. Гүйцэтгэх ажлын жагсаалт, дэлгэрэнгүй тайлбар:

#### **4.1. Цахим сургалт зохион байгуулах бэлтгэл хангах**

4.1.1. Сонгон судлах хичээлийг цахимаар судлах сурагчийн хичээлийн хуваарийг ЕБС-т хүргүүлэх

4.1.2. Цахим сургалтын "платформ" суурьтай ангиудыг бэлтгэх

4.1.3. Сургалт зохион байгуулах багшид хичээлийн хуваарийг өгч сургалтын бэлтгэл хангуулах

4.1.4. Цахим сургалтын сурагчдын үндсэн сургуулийн анги удирдсан багш нарын утасны дугаарыг нэгтгэж цахим сургуулийн багш нарт өгөх

#### **4.2. Цахим сургалт зохион байгуулах**

4.2.1. Хариуцсан судлагдахууны цахим сургалтын явцыг хянах

4.2.2. Хариуцсан судлагдахууны ирцийн мэдээллийг сургууль, сум, дүүрэг, нийслэлээр нэгтгэж тайланд бэлтгэх

4.2.3. Сурагч болон цахим сургуулийн багш нарт өөрийн үнэлгээний линк илгээж гүйцэтгэлд хяналт тавих

4.2.4. Ахлах багш нарт сургалтын ирц, өөрийн үнэлгээ, зохион байгуулалттай холбоотой мэдээллийг цаг тухайд нь өгч асуудлыг шийдэж тэмдэглэл хөтлөх

4.2.5. Ирцийн мэдээллийг нэгтгэж аймгийн БШУГ, НБГ-т мэдээлэл өгөх

4.2.6. Цахим сургалтын ирцийн мэдээлэл болон цахим ангид нэвтрэх зааварчилгааг сургуулийн АУБ, сурагчдад цахимаар өгч хамтран ажиллах

#### **3. Сургалтын явцад судалгаа, шинжилгээ хийх, тайлагнах**

1. Цахим сургалтын зохион байгуулалт, чанар, үр дүнд хяналт хийхэд ахлах менежер, менежер нартай хамтран ажиллах, шаардлагатай, мэдээллээр хангах;
2. Цахим сургалтын багш нарын хөлсөөр ажиллах гэрээг сунгах, цуцлах үйл ажиллагаанд санал өгөх.
3. Цахим сургалтын сурагчдын ирц, идэвх, оролцоог хянах, үр дүнд хяналт тавьж шаардлагатай мэдээллийг харьяа сургуулийн захиргаанд, ахлах менежер, менежертэй хамтран өгөх.
4. Цахим сургалтын явцад хийсэн судалгаа, шинжилгээ, асуулгын үр дүнг нэгтгэх, тайлагнах, гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээллийг нэгтгэн архивын нэгж үүсгэж хүлээлгэн өгөх.

#### **Багц № 8: ЦАХИМ СУРГАЛТЫН КОНТЕНТ ХӨГЖҮҮЛЭГЧ, ДИЗАЙНЕР МЕНЕЖЕРИЙН АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА /ОРОН ТОО -1/**

Тавигдах шаардлага:

- Компьютер График Дизайн, чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй,
- График дизайны программууд дээр ажиллах чадвартай,
- Компьютерын өргөн хэрэглээний программууд болон интернэтийн орчинд ажиллах чадвартай,
- Хувийн зохион байгуулалт сайтай, харилцааны ёс зүйн төлөвшил өндөр, бүтээлч багаар ажиллах чадвартай байх,

#### **ЦАХИМ СУРГАЛТЫН КОНТЕНТ ХӨГЖҮҮЛЭГЧИЙН ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР БА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАР ХҮРЭЭ**

Үйлчилгээний нэр: "Контент хөгжүүлэгч"

Нэг. Ерөнхий зүйл:

Хоёр. Зорилго: Сонгон судлах хөтөлбөрийг цахимаар хэрэгжүүлэх, сургалтын чанарыг үнэлэх, багшийн мэргэжил дээшлүүлэх хэрэгцээнд үндэслэн мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалтын явц, үр дүнг тайлагнах.

